



МОНГОЛБАНК

**НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ХӨДӨЛМӨРИЙН
ЗАХ ЗЭЭЛ, АЖИЛ ЭРХЛЭЛТЭД
ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ**

С.Мөнхчимэг¹

¹ Монголбанкны ССГ-ын ТСШ-ний албаны эдийн засагч. tunkhchimeg@mongolbank.mn

ХУРААНГУЙ

Уг судалгааны ажилд МУ-ын хөдөлмөрийн зах зээл дэх нийгмийн халамжийн нөлөөний сувгуудыг тодорхойлж, үнэлэхийг зорилоо. Судалгааг 2018 оны Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа, хөдөлмөрийн зах зээлийн талаарх боломжит тоон мэдээлэл, төсвийн халамжийн сангийн зарцуулалт зэргийг ашиглан гүйцэтгэсэн. Улмаар хөдөлмөрийн зах зээл дэх халамжийн нөлөөг олон хувьсагчтай энгийн регрессийн загварыг ашиглан тооцсоны үр дүнд халамжийн нийт зардал нэмэгдсэн нь ажиллах хүчний оролцооны түвшин, ажил эрхлэлт, бодит дундаж цалин, ажилгүйдэл зэрэгт нөлөөгүй болох нь тогтоогдсон. Харин зөвхөн хувиараа аж ахуй эрхлэх хандлагыг бага зэрэг бууруулах нөлөөтэй байна. Уг үр дүн тоон мэдээллийн олдоц, чанар, эконометрик загварын сонголтын тодорхой бус байдлаас ихээхэн шалтгаалж байгаа ба цаашид нийгмийн халамжийн хөтөлбөр бүрийн хувьд микро түвшний тоон мэдээллийг бүрдүүлж, халамжийн хөтөлбөр бүрийн хувьд хөдөлмөрийн зах болон эдийн засаг дахь нөлөөг нарийвчлан үнэлэх нь зүйтэй юм.

Түлхүүр үгс: Мөнгөн халамж, хөдөлмөрийн зах зээл, ажил эрхэлтийн түвшин, ажилгүйдэл, бодит цалин

JEL ангилал: D31, D52, D21, E21, E52

1. ОРШИЛ

Монгол Улсын Засгийн Газраас Дэлхийн зах зээл дээрх алт, зэс, нүүрс зэрэг уул уурхайн бүтээгдэхүүний үнэ өссөн 2000-аад оноос МУ-ын төсвийн орлого нэмэгдэхтэй зэрэгцэн тус орлогыг иргэдэд тэгш хүртээх, өрхийн орлогод дэмжлэг үзүүлэх зорилгоор суурь халамжууд дээр шинээр олон төрлийн халамжийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхэлсэн. 2005 оноос эх орны хишиг 10 мянга, Тавантолгойн сая 500 мянган төгрөгийн хувьцаа, түүний урьдчилан худалдан авалт, хүүхдийн мөнгөн тусламж 20 мянга, оюутны 70 мянга, шинээр гэрлэгсдийн 500 мянган төгрөгийн тусламж, ээжүүдийн, ахмад настны зэрэг олон төрлийн халамжийн хөтөлбөрүүдийг дурдаж болно. Гэвч зарим халамжийн хөтөлбөрүүд эдийн засгийн мөчлөг даган хэрэгжиж, төсвийн нөхцөл, шинээр ЗГ бүрдэх зэрэгтэй уялдан өөрчлөгдсөн эсвэл зогссон. Эдгээрээс зөвхөн хүүхдийн мөнгөн тусламжийг одоогоор тууштай хэрэгжүүлж байна.

Дээрх мөнгөн халамжуудыг нийт иргэдэд хавтгайруулан олгосноор улсын төсвийн ачаалал ихээхэн нэмэгдсэн, тухайлбал 2006 оноос хойш дунджаар ДНБ-ий 1.24 хувьтай тэнцэх хэмжээний халамжийн зардлыг улирал бүр улсын төсөвт тусган, зарцуулж иржээ. Түүнчлэн сүүлийн жилүүдэд тэтгэврийн зээлийг тэглэсэн, хүүхдийн 100 мянган төгрөгийг олгож эхэлсэн нь ЗГ-ын өр нэмэгдэхэд хүргэж байна. Ийнхүү нийгмийн халамж төсвийн ачаалал, улмаар улсын өрийг нэмэгдүүлэх сөрөг талтайгаас гадна иргэдийн бэлэнчлэх сэтгэлгээг урамшуулж, улмаар ажил эрхлэлтийг бууруулж болзошгүй байжээ. 2008 оноос МУ-ын ажиллах хүчний оролцооны түвшин, ажил эрхлэлтийн түвшин аажим буурчээ.

Түүнчлэн дээрх халамжийн хөтөлбөрүүдийн МУ-ын макро эдийн засаг, ялангуяа хөдөлмөрийн зах зээл дэх нөлөөний талаар судалгаа, шинжилгээ хомс байдаг, зөвхөн нийгмийн халамжийн ажиллах хүчний оролцооны түвшинд үзүүлэх нөлөө болон хүүхдийн мөнгөн тусламжийн эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтэд үзүүлэх нөлөөний талаар цөөн тооны судалгаа хийгджээ. Аливаа халамж газарзүйн байдал, нас, хүйс, боловсрол зэргийн ялгаатай байдлаас хамаарч тухайн иргэн болон өрхүүдэд ялгаатай нөлөө үзүүлдэг, иймээс тус нөлөөг судалж тогтооход өрх, иргэд зэргийн микро түвшний дэлгэрэнгүй тоон мэдээлэл зайлшгүй шаардлагатай, харин манай улсад уг тоон мэдээлэл хараахан бүрдээгүй байна.

Иймд уг судалгаанд халамжийн хөдөлмөрийн зах зээл дэх нөлөөний сувгуудыг тодорхойлох, мөн макро түвшний хөдөлмөрийн зах зээлийн тоон мэдээллүүдийг ашиглан улсын төсвөөс санхүүжигдэж буй халамжийн сангийн зарцуулалт хөдөлмөрийн зах зээлд ялангуяа ажиллах хүчний оролцоо, ажил эрхлэлтийн түвшин, ажилгүйдэл, хувиараа аж ахуй эрхлэх хандлага, бодит дундаж цалин зэрэгт хэрхэн нөлөөлж байгаа талаар судалахаар зорилоо. Түүнчлэн МУ-д одоогоор олгогдож буй халамжууд

өрхүүдэд хэрхэн тархсаныг 2018 оны Өрхийн Нийгэм Эдийн Засгийн Түүвэр судалгааны микро түвшний тоон мэдээллийг ашиглан харууллаа.


Судалгааны бүтцийн хувьд 2-р бүлэгт сэдвийн судлагдсан байдал, 3-р бүлэгт халамжийн хөдөлмөрийн зах зээл дэх нөлөөний сувгуудын талаар, 4-р бүлэгт эконометрик шинжилгээний үр дүн, 5 дугаар бүлэгт дүгнэлт, зөвлөмжийг тус тус танилцуулна.

2. СУДЛАГДСАН БАЙДАЛ

Улс орнууд нийгмийн халамжийг хэрэгжүүлэхдээ орлогын тэгш бус байдлыг бууруулах, эдийн засгийн өгөөжөөс иргэдэд тэгш хүртээх, мөн ахмадууд, хүүхдүүд, хөдөлмөрийн чадваргүй иргэд зэрэг нийгмийн зорилтот бүлгүүдэд мөнгөн тусламж олгох зорилгоор хэрэгжүүлдэг. Дийлэнхдээ иргэд нь эдийн засгийн үр өгөөжөөс тэгш бус хүртдэг, шударга бус байдал өндөр улс орнуудад нийгмийн халамж өндөр байдаг. Улс орнуудын ЗГ-уудаас тус үүргээ биелүүлэх арга зам нь янз бүр байгаагаас халамжийн нөлөө, үр дүн нь ялгаатай байдаг. Нөгөө талаас нийгмийн халамж нь иргэдийн залхуу хойрго байдлыг нэмэгдүүлж, ажил эрхлэлтийг бууруулдаг гэсэн хандлага байдаг.

Төрөөс олгож буй мөнгөн тусламж, халамж ард иргэдийн залхуу хойрго байдалтай хамааралтай байгаа эсэхийг илрүүлэх зорилгоор (Pavao, 2016) нийгмийн халамжийг ЗГ-аас яагаад хэрэгжүүлдэг талаар хэд хэдэн улсуудын иргэдээс асууж, үр дүнг нэгтгэжээ. Тэрээр тус асуултад асуулгад оролцсон иргэн хэрвээ тухайн улсад шударга бус байдал өндөр байдаг гэж хариулсан бол 0, харин залхуурал байдаг гэж хариулсан бол 1 гэсэн тоог харгалзуулсан ба тухайн улсын дундаж оноог **Зураг 1**-д нэгтгэж харууллаа. Үүнд босоо тэнхлэгт халамжийн зардлын ДНБ-д эзлэх хувийг харуулсан.

Зураг 1. Халамжийн зардлын ДНБ-д эзлэх хувь, шалтгаан



Судалгааны үр дүнд дийлэн улс орнууд, ялангуяа Зүүн Европын улс орнууд болох Украин Эстон, Беларусь, Серби, Румын, Молдав, Жүрж, Армен улсуудад халамжийн хэмжээ харьцангуй өндөр байдаг бөгөөд иргэд нь үүнийг ихэвчлэн шударга бус байдалтай холбон тайлбарлажээ.

Эх сурвалж: Абхижит, Рена Ханна, Габриел, Бенжамин

Харин зөвхөн Филиппин улсын хувьд залхуурал харьцангуй өндөр байдаг, үүний улмаас халамжийн хэмжээ тус улсад харьцангуй бага байжээ.

Халамжийн хөдөлмөрийн зах зээлийн нөлөөлөх сувгийг дийлэнхдээ өрхийн түвшний тоон мэдээлэл дээр үндэслэн тогтоох хандлага түгээмэл байдаг бөгөөд тухайн нэг халамжийн хөтөлбөрийн хувьд нийт болон эрэгтэй, эмэгтэйчүүдийн ажил эрхлэлт, хувиараа болон ХАА эрхлэх хандлага, ажилласан цаг, цалин, хөлсөнд хэрхэн нөлөөлсөн эсэхийг судалсан судалгаанууд түгээмэл байдаг. Хүснэгт 1-д хэд хэдэн улс орнуудын хувьд ялгаатай төрлийн нийгмийн халамжийн хөдөлмөрийн зах зээлд үзүүлэх нөлөөний талаар хийгдсэн судалгаануудын үр дүнг хураангуйлан харууллаа.

Хүснэгт 1. Эмпирик судалгааны тойм

Судалгааны нэр	Улс, хөтөлбөр	Хөтөлбөрийн төрөл	Үр дүн
1 (Garganta & Gasparini, 2015)	Аргентин	AUH	Нөхцөлт мөнгөн тусламж (НМТ) Тус халамж хүүхэдгүй өрхүүдтэй харьцуулахад хүүхэдтэй өрхүүдийн албан ажил эрхлэлтийг бууруулсан.
2 (Foguel & Barros, 2010)	Бразил	Хүүхдээ сургуульд хамрагдуулах, эмнэлгийн үйлчилгээ авах нөхцөлтэй ядуу өрхүүдэд чиглэгдсэн	НМТ Ажил эрхлэлт эмэгтэйчүүдийн хувьд 1 нэгж хувиас багаар нэмэгдсэн бол эрэгтэйчүүдийн хувьд 2-3 нэгж хувиар нэмэгдсэн. Харин эмэгтэйчүүдийн хувьд долоо хоногт ажиллах цаг 0.6-2.6 цагаар буурсан, эрэгтэйчүүдийн хувьд 0.6-1.6 цагаар нэмэгджээ.
3 (Ribas & Soares, 2011)	Бразил,	15- 90 ам.дол (Болса Фамилия)	НМТ Ажил эрхлэлтэд тодорхой нөлөө ажиглагдаагүй. Харин албан сектор дахь ажил эрхлэл буурсан.
4 (De Brauw, Gilligan, Hoddinott, & Roy)	Бразил		НМТ Ажил эрхлэлтэд илт нөлөө ажиглагдаагүй. Долоо хоног тутмын албан секторын ажлын 8 цаг албан бус секторт шилжсэн.
5 Ferreira.Filmer & Schady (2009)	Камбодж	CESSP	НМТ Ажил эрхлэлт, ажлын цаг, цалин зэрэгт тодорхой нөлөө ажиглагдаагүй.
6 Chen et al (2013)	БНХАУ	Ди Бао	Нөхцөлт бус мөнгөн тусламж (НБМТ) Нийт орлого нэмэгдсэн боловч зан, үйлийн тодорхой өөрчлөлт ажиглагдаагүй. Судлаачид хөтөлбөр хэрэгжүүлэхэд оролцож буй хүмүүс нь шаардлагатай хүн амыг хамарч чадаагүй гэж дүгнэсэн.

7	(Attanasio, Gomez, Rojas, & Vera-Hernandez, 2004)	Колумб	Familias en Accion	НМТ	Ажил эрхлэлтэд тодорхой нөлөө ажиглагдаагүй. Гэхдээ хөдөөгийн эрэгтэйчүүдийн ажил эрхлэлт 3 нэгж хувиар нэмэгдсэн.
8	(Galiani & McEwan, 2013)	Хондурас	Өрхийн бүтцээс хамааран сард 4-23 ам.дол олгосон. (PRAF II)	НМТ	Ажил эрхлэлтэд тодорхой нөлөөгүй. Өрхийн хувьд эрэгтэйчүүдийн ажил эрхлэлт бага зэрэг нэмэгдсэн, эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтэд нөлөөгүй
9	(Alzia, 2013)	Хондурас	PRAF II	НМТ	Ажил эрхлэлтэд нөлөөгүй байсан.
10	(Asfaw, Davis, Dewbre, Handa, & Winters, 2014)	Кени	Нялх болон эмзэг бүлгийн хүүхдийн мөнгөн тусламж	НБМТ	Нийт ажил эрхлэлтэд үзүүлэх нөлөөг тооцоогүй. Эмэгтэйчүүдийн ХАА-н бус ажил эрхлэлт буурсан, харин эрэгтэйчүүдийнх өссөн. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн аль ч тохиолдолд ХАА-н ажил эрхлэлт буураагүй, харин цалин хөлс буурчээ.
11	(Haushofer & Shapiro, 2013)	Кени	GiveDirectly	НБМТ	Орлогын үндсэн эх сурвалж нь цалингийн, ХАА-н ажил, эсвэл ХАА-н бус ажил эрхлэлт эсэх дээр тодорхой үр дүн ажиглагдаагүй.
12	Covarrubias et al. (2012)	Малави	Нийгмийн мөнгөн шилжүүлэг	НБМТ	Цалинтай ажил эрхлэлт сар бүр 7 хоногоос 3-5 өдөр болж буурсан. Нийт ажил эрхлэлтэд дэх нөлөөг тооцоогүй.
13	Skoufias et al.(2008)	Мексик	Сарын 13 ам.дол олгосон. (PAL)	НБМТ	Нийт ажил эрхлэлтэд нөлөөгүй байсан. Харин ХАА-н ажлаас ХАА-н бус ажил руу шилжилт хийгдсэн дүр зураг ажиглагдсан.
14	Parker & Skoufias (2000)	Мексик	Progresa	НБМТ	Нийт ажил эрхлэлтэд нөлөө үзүүлээгүй.
15	Skoufias & Vincenzo Di Maro (2008)	Мексик	Progresa	НБМТ	Нийт ажил эрхлэлт болон ажилласан цагт нөлөөгүй байсан.
16	Alzua, Cruces & Ripani (2013)	Мексик	Progresa	НБМТ	Нийт болон ХАА-н ажил эрхлэлтэд нөлөөгүй байсан. Харин хөдөлмөрийн насны эмэгтэйчүүдийн долоо хоног дутмын суурь ажлын цаг 42 цагаас 0.4-өөр нэмэгджээ.

17	Maluccio & Flores (2005)	Никарагуа	Жилийн 224 ам дол, сургуулийн хамрагдалт	НБМТ	Нийт болон эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтэд нөлөөгүй, эрэгтэйчүүдийн долоо хоног тутмын ажлын цаг 5-аар буурчээ.
18	Maluccio (2007)	Никарагуа	бүрд жилийн 112 ам.дол, хүүхэд бүрт жилийн 21 ам.дол олгосон. (RPS)	НБМТ	Нийт ажил эрхлэлтэд нөлөөгүй, эмэгтэйчүүдийн долоо хоног тутмын ажлын цаг 4, эрэгтэйчүүдийнх 8 цагаар тус, тус буурчээ.
19	Alzua, Cruces & Ripani (2013)	Никарагуа		НМТ	Нийт ажил эрхлэлтэд нөлөөгүй. Хэдийгээр эрэгтэйчүүдийн ажилласан цаг долоо хоног тутам 1.5-с 2.7, эмэгтэйчүүдийнх 4-с 5.7 цагаар буурсан ч статистикийн хувьд ач холбогдолгүй үнэлэгджээ.
20	Nasan (2010)	Пакистан	Эмэгтэй оюутнуудад чиглэгдсэн НБМТ	НБМТ	Цалинтай ажилд өдөр болгоны 47 минут бүрээс 24-32 минутаар буурах нөлөө байсан ч, өрхийн ажил суурь 600 минутаас 100-120 минутаар нэмэгдсэн. Нийт ажил эрхлэлт дэх нөлөөг тооцоогүй.
21	Chaudhury et al. (2013)	Филлипин	Хүүхдийн тооноос хамааран сар бүр 11-30 ам.дол олгосон. (PPP)	НМТ	Нийт ажил эрхлэлт, болон ажлын цагт нөлөөгүй байсан.
22	Amarante et al. (2011)	Уругвай	PANES	НБМТ	Тус програм нь албан секторын цалинг бууруулсан. Албан бус секторын тоон мэдээлэл байгаагүй.
23	American Institutes for Research (2013)	Замби	Хүүхдийн мөнгөн тусламж	НБМТ	Хөдөлмөрийн орлого эрс буурсан боловч ХАА-н бус үйлдвэрлэлийн болон ХАА-н ажил эрхлэлт нэмэгдсэнээр цалин, хөлс буураагүй.

Хүснэгтээс харахад дээрх улсуудад хэрэгжүүлсэн халамжийн хөтөлбөрүүд дийлэнхдээ орлого багатай өрхүүдэд чиглэгдсэн ба ажил эрхлэлт, ажилласан цаг, эмэгтэйчүүдийн ажил эрхлэлт, цалин хөлс, иргэдийн ХАА эрхлэх хандлагад хэрхэн нөлөөлснийг шинжилсэн судалгаанууд түгээмэл байна. Тухайлбал дээрх халамжийн хөтөлбөрүүдийн үр дүнд Аргентин, Бразил, Малави зэрэг улсад нийт албан секторын ажил эрхлэлт, ажилласан цаг *буурсан*, Камбож, БНХАУ, Колумб, Гондурас, Мексик, Никарагуа, Филиппин зэрэг улсад *нөлөөгүй*, Замби, Пакистан улсуудад *нэмэгдсэн*. Харин эмэгтэйчүүдийн ажил эрхлэлт Мексик, Колумб улсад *нэмэгдсэн*, Бразил, Гондурас, Никарагуа зэрэг улсад *буурсан*. Цаашилбал цалин, орлогын хэмжээ Уругвай, Кени улсуудад *буурсан*, Замби, Камбож улсад *нөлөөгүй* байв.

МУ-д 2006 оноос хавтгайруулан олгож эхэлсэн халамжийн ажил эрхлэлт дэх нөлөөний талаар өрхийн түвшний микро тоон мэдээлэлд үндэслэн сүүлийн үед (Batchuluun & Dalkhjab, 2014) болон (Dandarchuluun, 2019) судалгаанууд хийгджээ.

Тухайлбал “хүүхдийн мөнгөн тусламж”-ийн эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтэд үзүүлэх нөлөөг (Dandarchuluun, 2019) судалж, ҮСХ-ны Өрхийн Нийгэм Эдийн Засгийн Түүвэр судалгааны панел өгөгдлийг ашиглан МУ-д хүүхдийн мөнгийг олгож эхлэхээс өмнөх үе (2002-2003), дараах үе (2007-2008)-үүдийг харьцуулахад хүүхэдтэй эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин халамжаас шалтгаалан 12.3 нэгж хувиар буурсныг илрүүлсэн. Мөн хүүхэдтэй эмэгтэйчүүдийн ажилласан цаг жилийн туршид 155.3 цагаар буурсан тооцоолжээ.

Харин ҮСХ-ны Хөдөлмөр Эрхлэлтийн Түүвэр Судалгааны панел тоон өгөгдлийг ашиглан (Batchuluun & Dalkhjab, 2014) ажиллах хүчний оролцооны түвшинд халамж хэрхэн нөлөөлснийг шинжилж халамжийн бодлого хэрэгжүүлж эхэлснээс хойш ажиллах хүчний оролцооны түвшин 3.4-5.4 нэгж хувиар буурсныг тогтоожээ. Цаашилбал ажиллах хүчний оролцооны түвшин нь эрэгтэй, эмэгтэй болон хот, хөдөөгөөр ялгаатай байжээ. Үүний нэг шалтгаан нь хотын эмэгтэйчүүдтэй харьцуулахад хөдөөгийн эмэгтэйчүүд илүү бага насны хүүхэдтэй байх хандлагатай, харин хотын эмэгтэйчүүд 15 наснаас дээш насны хүүхэдтэй байх хандлагатай байдаг тул эмэгтэйчүүдийн ажил эрхлэлт хөдөөтэй харьцуулахад өндөр байдаг. Мөн хотын эмэгтэйчүүдийн боловсролын түвшин нь ажиллах хүчний оролцооны түвшинд ихээхэн нөлөөтэй байв. Харин эрэгтэйчүүдийн хувьд хөдөөд ажиллах хүчний оролцооны түвшин бага байгаа нь нүүдэлчин мал аж ахуй эрхлэлттэй салшгүй холбоотой байжээ. Түүнчлэн тус судалгаанд зах зээл дээр тогтож буй цалин, хөлсөнд ажлын туршлага болон боловсрол өндөр нөлөөтэй байв. Гэвч боловсролын түвшин нь эрэгтэй, эмэгтэйчүүдэд, хот хөдөөд ялгаатай байдлаар нөлөөлж байв. Тухайлбал цалингийн цэвэр зөрүү 0.07, харин сургуульд хамрагдсан жил, нас, байрлал зэргийг тооцвол уг зөрүү 0.132 болж өсч байжээ.

МУ-ын хувьд хөдөлмөрийн зах зээл, ажиллах хүчний оролцооны түвшний талаар макро түвшний тоон мэдээлэл ашиглан хийсэн судалгаа ховор байдаг. Харин олон улсад хийгдсэн судалгаануудаас дурдвал (Grigoli, 2018) хөдөлмөрийн зах зээл, ажиллах хүчний оролцооны түвшинд нөлөөлж буй хүчин зүйлсийн талаар хөгжингүй улсуудын панел тоон мэдээллийг ашиглан, шинжилсэн. Тус судалгаанд ажиллах хүчний оролцооны түвшинд хөдөлмөр эрхлэлтийн бодлого болон институцийн нөхцөл байдал чухал нөлөөтэй болох нь тогтоогдсон. Тухайлбал үүнд хөдөлмөр эрхлэлтийн татвар, ажилгүйдлийн тэтгэмжийн тогтолцоо, хөдөлмөрийн зах зээлд чиглэгдсэн ЗГ-аас олгож буй шилжүүлэг, тусламж, хөдөлмөрийн шилжилт,

үйлдвэрчний эвлэлийн тархалт, цалинг тодорхойлох хүчин зүйлс, өрхийн дотор болон гадуурх хөдөлмөр эрхлэлтийн бодлого (хүүхдийн мөнгө, боловсрол, хагас цагаар ажиллах боломж, ээжийн чөлөө гэх зэрэг), тэтгэвэрт гарах нас, тэтгэврийн тогтолцоо зэрэг багтана. Цаашилбал бүтцийн өөрчлөлт, боловсролын түвшин, эдийн засгийн мөчлөг зэрэг нь ажил эрхлэлт, хөдөлмөрийн зах дахь оролцоонд нөлөөлж байжээ. Харин хувь хүмүүсийн хувьд хийсэн шинжилгээний үр дүнд технологийн дэвшил ажиллах хүчийг шахан гаргах хандлага нэмэгдсэн ч боловсрол болон хөдөлмөрийн зах зээлд чиглэсэн бодлогоор (халамж гэх мэт) сөрөг нөлөөг бууруулах боломжтой гэж дүгнэжээ.

3. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН АЖИЛ ЭРХЛЭЛТЭД НӨЛӨӨЛӨХ СУВГУУД

МУ-д нийгмийн халамжийн хөдөлмөрийн зах зээлд хэрхэн нөлөөлж буйг тооцохын өмнө төрөл бүрийн халамж, мөнгөн тусламж, шилжүүлэг ямар сувгаар хөдөлмөрийн зах зээлд нөлөөлж болохыг тодорхойлох шаардлагатай. (Baird, McKenzie, & Ozler, 2018) аливаа улсын ЗГ-аас олгож буй мөнгөн тусламж нь эрэгтэй, эмэгтэйчүүдийн ажил эрхлэлт, хувиараа ажил эрхлэлт болон хөдөлмөрийн хөлсөнд хэд хэдэн сувгаар нөлөөлдөг болохыг тодорхойлсон бөгөөд түүнийг Хүснэгт 2-д нэгтгэн харууллаа. Үүнд:

Мөнгөн тусламж орлогыг түр хугацаанд нэмэгдүүлснээр иргэдийн чөлөөт цагийг эрхэмлэх хандлага нэмэгдэж, ажил эрхлэлтийг бууруулдаг (*орлого/амралтын орлуултын суваг*). Гэвч зарим мөнгөн тусламж бага орлоготой өрхийн гишүүдийн эрүүл мэнд (*эрүүл мэндээс үүдэлтэй бүтээмжийн суваг*), хүмүүн капиталыг (*хүмүүн капитал хуримтлалын суваг*) сайжруулснаар урт хугацаанд ажил эрхлэлтэд эерэг нөлөө үзүүлдэг. Мөн хувиараа ажил эрхлэлт (*хувиараа аж ахуй эрхлэлтийн хөрөнгийн суваг*) болон эрсдэлтэй бизнес эхлүүлэх (*даатгалын суваг*) хандлага нэмэгддэг, ялангуяа эрэгтэйчүүдийн хувьд уг суваг илүү хүчтэй байдаг ажээ. Цаашилбал халамжид хамрагдсан иргэд илүү боломж бүхий ажил хайх хандлага нэмэгдсэнээр (*ажил хайхад хөрөнгө оруулах суваг*) богино хугацаанд ажил эрхлэлтэд сөрөг нөлөө үзүүлэх ч урт хугацаанд цалин, орлого өсөхөд нөлөөлдөг. Гэвч зарим нөхцөлт мөнгөн тусламж (*нөхцөлт үйл ажиллагаанаас хамаарах нөхцөлт суваг*) ажиллах цагийг бууруулж, ажил эрхлэлтэнд сөргөөр нөлөөлдөг, харин нөхцөлт ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх (*ажиллах/ажиллахгүй байх нөхцөлийн нөхцөлт нөлөө*) тухайн нөхцөлөөс хамаарч, ажил эрхлэлтэд харилцан адилгүй нөлөөлдөг. Эцэст нь цалин хөлстэй ажлаас хувиараа ажил эрхлэлт рүү шилжих боломж өндөр, тусламжид хамрагдсан иргэд цалинтай ажлаас гарсан тохиолдолд ЗГ-ын шилжүүлгүүд тусламжид хамрагдаагүй иргэдийн ажил эрхлэлт, орлогыг нэмэгдүүлэх боломжтой. Улмаар хүмүүс чөлөөт цагийг эрхэмлэх хандлага

нэмэгддэг байна (ерөнхий тэнцвэрийн нөлөө).

Ялгаатай мөнгөн тусламж хөдөлмөрийн зах зээлд ялгаатай нөлөө үзүүлдэг. Хэд хэдэн төрлийн ЗГ болон бусад мөнгөн тусламжуудын ажил эрхлэлтэд үзүүлэх нөлөөг Хүснэгт 3-д нэгтгэж харууллаа. Үүнд:

ЗГ-ын “*нөхцөлт мөнгөн тусламж*” нийт ажил эрхлэлт, амралтад нөлөөлөхгүй ч хувиараа аж ахуй эрхлэлтэд бага зэрэг нөлөөтэй, бизнес эрхлэлтийг богино хугацаанд нэмэгдүүлдэг. Харин “*нөхцөлт бус мөнгөн тусламж*” хөдөлмөрийн насны хүмүүсийн хувьд ажлаа солих, хувиараа аж ахуй эрхлэх хандлагыг нэмэгдүүлдэг, ахмадуудад олгодог тэтгэвэр тэтгэмж тэдний хөдөлмөр эрхлэлтийг бууруулдаг, тэдгээртэй хамт амьдардаг хүмүүсийн ажил эрхлэлтэд янз бүрээр нөлөөлдөг байна. Цаашилбал “*буяны болон хүмүүнлэгийн мөнгөн тусламж*”, “*мөнгөн гуйвуулга*” ажил эрхлэлтэд харьцангуй бага нөлөөтэй байна. Харин “*ажил хайх*” болон “*бизнес эхлүүлэх*”-д олгох мөнгөн тусламж богино хугацаанд ажил хайлт, бизнес эрхлэлтийг нэмэгдүүлж хөдөлмөр эрхлэлтийг бууруулдаг боловч хөдөлмөрийн хөлс болон бизнесийн орлогыг урт хугацаанд өсгөх нөлөөтэй. Мөн шилжилт хөдөлгөөн нэмэгддэг. Томоохон бизнесүүдэд олгосон мөнгөн тусламж ажлын байрны тоог нэмэгдүүлэх нөлөө үзүүлжээ.

Хүснэгт 2. Халамжийн насанд хүргэгчдийн хөдөлмөр эрхлэлт дэх нөлөө, сувгуудаар

1	<i>Орлого/амралтын орлуултын нөлөө</i>	Ажил эрхлэлт хүний тооны болон ажиллах цагийн аль ч тохиолдолд буурдаг, харин нэгж цагт ногдох цалин, хөлсөнд нөлөөгүй. Хэрэв удаан хугацаатай, их хэмжээтэй, мөн хүлээн авагчид ямар нэг нөхцөл тавьдаггүй тохиолдолд өндөр нөлөөтэй.
2	<i>Эрүүл мэндээс үүдэлтэй бүтээмжийн нөлөө</i>	Ажил эрхлэлт, нэгж цагт ногдох цагийн хөлс нэмэгдэнэ. Уг суваг түгээмэл ашиглагддаггүй, нэн ядуу хүмүүст илүү нөлөөлдөг.
3	<i>Хувиараа аж ахуй эрхлэлтийн хөрөнгийн нөлөө</i>	Хувиараа ажил эрхлэлт хүний тооны болон ажиллах цагийн аль ч тохиолдолд нэмэгддэг, хувиараа аж ахуй эрхлэлтээс олох орлого нэмэгддэг. Нийт ажил эрхлэлтэд бага хэмжээний, эерэг нөлөө үзүүлдэг. Бизнес эрхлэгчдэд зориулсан хөтөлбөрийн хувьд эрэгтэйчүүдэд илүү нөлөөлдөг. Мөн мөнгөн шилжүүлэг, нөхцөлт бус мөнгөн тэтгэмж илүү нөлөөтэй.
4	<i>Хүмүүн капитал хуримтлалын нөлөө</i>	Халамжид хамрагдсан өрхөд өссөн хүүхдийн сургуульд хамрагдалт нэмэгдэж, урт хугацаанд насанд хүрэх үед нь хүмүүн капитал нэмэгдэж, орлого өсдөг. Харин нийт ажил эрхлэлт дэх нөлөө багатай. Одоогийн нөхцөлт мөнгөн тусламжийн нөлөө нь маш бага, эерэг байжээ.
5	<i>Даатгалын нөлөө</i>	Ажилчид ажлаа солих нь нэмэгддэг, тухайлбал хувиараа аж ахуй эрхлэх, шилжин суурьших эсвэл тариалангийн аж ахуйд хүмүүс тариалангаа өөрчлөх буюу илүү эрсдэлтэй, орлого өндөртэй ажил руу шилждэг. Харин ажил эрхлэлтэд бага нөлөөтэй. Мөнгөн тусламж нь илүү найдвартай, олон удаагийн давтамжтай, тухайлбал зарим нөхцөлт тусламж илүү нөлөөтэй.
6	<i>Ажил хайхад хөрөнгө оруулах нөлөө</i>	Илүү сайн ажил хайх хандлага нэмэгддэг тул богино хугацааны ажил эрхлэлт буурдаг. Улмаар дунд хугацаанд ажлын чанар, нэг цагт ногдох цалин хөлс нэмэгддэг. Иймд ажил эрхлэлтэд бага нөлөө үзүүлдэг. Ийм төрлийн халамжууд ихэвчлэн ажил хайхад зориулагдсан, тухайлбал шилжин суурьших тээврийн зардлыг санхүүжүүлэх мөнгө тусламжууд байдаг.

7	Ажиллах/ ажиллахгүй байх нөхцөлийн нөхцөлт нөлөө	Хэрвээ тусламж нь бизнес эрхлэх, эсвэл тусгай үйл ажиллагаа эрхлэх нөхцөл тавьдаг бол ажил эрхлэлтийг нэмэгдүүлдэг. Тухайлбал жижиг дунд үйлдвэрлэгчдэд өгсөн тусламжийн хувьд тус суваг хүчтэй байна. Хэрвээ ажилгүй иргэдэд олговол ажил эрхлэлт, орлогыг бууруулах нөлөөтэй. Өндөр болон дунджаас дээш орлоготой улсуудад нөлөө нь хүчтэй, харин бага болон дунджаас доогуур орлоготой улсуудад нөлөө багатай.
8	Нөхцөлт үйл ажиллагаанаас хамраах нөхцөлт нөлөө	Хувь хүмүүс мөнгөн тусламж авахын тулд аливаа нэг үйл ажиллагаанд илүү их цаг зарцуулах шаардлага тавьдаг бол ажил эрхлэлтийг бууруулах нөлөөтэй. Гэхдээ судлагдсан байдал хязгаарлагдмал байна. Харин хүүхдээ сургуульд хамрагдах нөхцөл тавих үед эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтийг нэмэгдүүлдэг. Дийлэнхдээ нөхцөлт мөнгөн тусламжийн хэлбэртэй.
9	Хүмүүн капитал/ айлгах нөлөө	Хэрвээ энэ төрлийн халамж түр зуурын шинжтэй бол хүмүүс чөлөөт цагийг эрхэмлэх эсвэл ажил эрхлэлт нэмэгдэх нь харилцан эсрэг нөлөөлдөг. Гэхдээ одоогоор нарийн судлагдаагүй байна.
10	Ерөнхий тэнцвэрийн нөлөө	Цалин хөлстэй ажлаас хувиараа ажил эрхлэлт рүү шилжих боломж өндөр болон тусламж авсан иргэд цалинтай ажил эрхлэлтээс гарсан тохиолдолд ЗГ-ын шилжүүлгүүд тусламжид хамрагдаагүй иргэдийн ажил эрхлэлт, орлогыг нэмэгдүүлэх боломжтой. Улмаар хүмүүс чөлөөт цагийг илүү эрхэмлэх хандлага нэмэгддэг. Гэхдээ зарим орнуудад хэрэгжсэн нэн ядуу хүмүүст зориулсан хөтөлбөрүүд нь хөдөө тосгон дахь цалин, хөлсийг нэмэгдүүлжээ.

Эх сурвалж: Baird et all (2018)

Хүснэгт 3. Мөнгөн тусламж ба насанд хүрэгчдийн ажил эрхлэлт	
ЗГ-ын мөнгөн тусламж (Нөхцөлт)	- Нийт ажил эрхлэлт, амралтад нөлөөгүй, хувиараа аж ахуй эрхлэлтэд бага зэрэг нөлөөтэй, бизнес эрхлэлтийг богино хугацаанд нэмэгдүүлдэг. - Тусламжид хамрагдсан гэр бүлд өссөн хүүхдийн ирээдүйн хөдөлмөр эрхлэлтэд ялгаатай нөлөө үзүүлсэн.
ЗГ-ын мөнгөн тусламж (Нөхцөлт бус)	- Хөдөлмөрийн насны хүмүүст олгосон мөнгөн тусламжууд ажлаа солих, хувиараа аж ахуй эрхлэх, ХАА-н үйлдвэрлэл эрхлэх хандлагыг нэмэгдүүлдэг. - Ахмадуудад олгосон тэтгэвэр, тэтгэмж тэдгээрийн хөдөлмөр эрхлэлтийг бууруулдаг. Харин хамт амьдарч буй хүмүүсийн ажил эрхлэлтэд янз бүрээр нөлөөлдөг. Нүүх, хувиараа аж ахуй эрхлэх эсвэл зарим нь чөлөөт цагийг эрхэмлэх зэрэг хандлагуудыг нэмэгдүүлдэг байна.
Буяны болон хүмүүнлэгийн тусламжууд	- Гамшиг тохиолдсон эсвэл дүрвэгсэд ихтэй үе биш л бол нийт ажил эрхлэлтэд богино хугацааны нөлөө үзүүлэхгүй, харин дүрвэгсдийн ажил эрхлэлтийг бууруулна.
Мөнгөн гуйвуулга	- Цөөн судалгаанууд урт хугацаанд нөлөө үзүүлнэ гэж үздэг. - Насанд хүргэгчдийн ажил эрхлэлтэд маш бага нөлөөлнө. Зарим тохиолдол хувиараа аж ахуй эрхлэгчдэд эерэг нөлөө үзүүлнэ. Ерөнхий тохиолдолд нөлөөгүй.
Ажил хайх мөнгөн тусламж	- Ажил хайлтыг нэмэгдүүлнэ, улмаар ажил эрхлэлтийг богино хугацаанд бууруулна. Өндөр цалинтай ажил эрхлэлтийг өсгөнө. Нүүх буюу ялгаатай хөдөлмөрийн захад ажил хайхад татаас олгох үед нөлөө нь ихэсдэг.

<i>Бизнес эхлүүлэх, өсгөх мөнгөн тусламж</i>	- Бизнесийн үйл ажиллагаа эхлүүлэх, үргэлжлүүлэхэд бага хэмжээний мөнгөн тусламж үзүүлэх нь бизнесийн орлогыг нэмэгдүүлдэг.
	- Ажил эрхлэлт болон хөдөлмөрийн орлогын нөлөө нь эерэг ч буурдаг. Томоохон бизнесүүдэд олгох ихээхэн хэмжээний тусламж ажлын байрыг нэмэгдүүлдэг.
<i>Мөнгөн, сургалтын, баялгын мөнгөн тусламж</i>	- Хэт ядуурлыг бууруулах хөтөлбөр мал аж ахуй эрхлэлтийг илүү нэмэгдүүлж, нийт ажил эрхлэлт, орлогыг нэмэгдүүлдэг. Нөлөө нь тусламжийн хэлбэрээс хамаарна.
	- Ерөнхий тэнцвэрийн нөлөө нь хөдөөд МАА-аас бусад ажлын цалин, хөлсийг нэмэгдүүлнэ.

Эх сурвалж: Baird et al (2018)

4. МУ-ЫН НИЙГМИЙН ХАЛАМЖ БА ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ

а. Нийгмийн халамжийн бүтэц, төрөл


Нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийг нийгмийн халамжийн тухай хууль (2012) болон хөтөлбөрт хамрагдах шалгуурыг тогтоосон бусад хууль тогтоомжид тодорхойлсон байдаг. Эдгээр хөтөлбөрүүдийн хүрээнд 2019 оны байдлаар (i) нийгмийн халамжийн тэтгэвэр 111.6, (ii) нийгмийн халамжийн тэтгэмж 78.0, (iii) нийгмийн халамжийн үйлчилгээ, үүнд олон нийтийн оролцоонд түшиглэсэн үйлчилгээ болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээ 1.8, (iii) алдар цолтой ахмадад олгох тусламж хөнгөлөлт 5.1, (iii) ахмад настанд олгох тусламж хөнгөлөлт 30.5, (iii) хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох тусламж хөнгөлөлт 11.5, (iv) эх, хүүхдэд зориулсан тэтгэмж 114.1 тэрбум төгрөгийн тэтгэмжийг тус тус олгожээ. Дээрх хөтөлбөрүүдээс гадна ХАХНХЯ эрдэс баялгийн ашгийг ирээдүйн үе рүү дахин хуваарилах зорилготой “Хүүхдийн мөнгөн хөтөлбөр” (ХМХ) хэрэгжүүлдэг. ХМХ нь нийгмийн халамжийн улсын төсвөөс тусдаа “Хүний хөгжил сан”-гаас санхүүждэг бөгөөд 0-18 насны бүх хүүхдэд сар бүр 20 мянган төгрөг (ойролцоогоор 11 ам.доллар)-ийн мөнгөн тэтгэмж олгодог бөгөөд 2019 оны байдлаар 229.6 тэрбум төгрөг олгожээ. Хүснэгт 4-т МУ-ын нийгмийн халамжийн дэлгэрэнгүй задаргааг харууллаа.

Хүснэгт 4. МУ-ын нийгмийн халамжийн сангийн зарцуулалт

Үзүүлэлтүүд	2019	2020.3 сар
1. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	303.8	76.3
Нийгмийн халамжийн тэтгэвэр	111.6	29.3
Ахмад настны тэтгэвэр	5.6	1.7
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр	74.5	19.4
16 насанд хүрсэн одой иргэний тэтгэвэр	0.2	0.1
Тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхэд	31.2	8.2
Өрх толгойлсон эх, эцгийн тэтгэвэр	0.0	0.0
Нийгмийн халамжийн тэтгэмж	78.0	19.9
Асаргааны тэтгэмж	47.7	13.3
Бүтэн өнчин хүүхдийг үрчилж авсан болон эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг асран хамгаалж, харгалзан дэмжиж байгаа иргэний	2.0	0.5
Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас сэтгэл санааны болон бие махбодын хохирол хүлээж хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг асран хамгаалж, харгалзан дэмжиж байгаа иргэний	0.3	0.1
Тэжээн тэтгэх хүүхэдгүй, ганц бие ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй ганц бие иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэний	0.2	0.0
Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэнийг асарч байгаа иргэний	45.2	12.7
Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж	30.4	6.6
Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	114.1	27.1
0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж	91.2	21.3
Жирэмсэн эхийн тэтгэмж	13.3	3.0
Ихэр хүүхдийн тэтгэмж	1.8	0.4
Гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	7.8	2.4
2. Хүүхдийн мөнгөн тэтгэмж	229.6	66.5
Алдарт эхийн одонгийн мөнгөн тусламж	333.8	54.2
3. Нийгмийн хөгжлийн үйлчилгээ	35.7	14.4
Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ	35.7	14.4
4. Насны хишиг	21.6	11.1
5. Нийгмийн халамжийн тусламж хөнгөлөлт	47.0	5.7
Ахмад настанд үзүүлэх тусламж, хөнгөлөлт	30.5	3.1
Алдар цолтон ахмад настанд үзүүлсэн нэмэгдэл, хөнгөлөлт	5.1	1.2
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	11.5	1.4
7. Бусад	2.5	0.3
Цаатан иргэний тэтгэмж	0.7	0.2
Нийгмийн халамжийн үйлчилгээ	1.8	0.1
Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ	1.6	0.1
Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ	0.2	0.0

Эх сурвалж: YCX

Зураг 2. Нийгмийн халамжийн зардал




Эх сурвалж: YCX, CЯ


2006-2020 оны улсын төсвийн зардалд тусгагдсан халамжийн сангийн зарцуулалтаас харвал халамжийн зардал эдийн засгийн өсөлттэй уялдан тасралтгүй өсчээ. 2006 оноо дунджаар ДНБ-ны 1.24%-тай тэнцэх зардлыг зарцуулжээ. Уг хувь хэмжээ 2008, 2009 оны санхүү эдийн засгийн хямралын үед 4-5%, эдийн засаг хүндэрсэн 2015, 2016 онуудад 3-4% болж, тус тус нэмэгдэж байжээ.

Харин өрхийн түвшинд 2018 онд ӨНЭЗС судалгаанд хамрагдсан нийт 16455 өрхийн тоон мэдээллээс харвал:


1а. Өрхийн орлого, орлогын бүлгээр



1б. ЗГ-ын шилжүүлэг, орлогын бүлгээр



1в. ЗГ-ын шилжүүлэг, орлогын бүлгээр



Зураг 3. МУ-ын нийгмийн халамж, бүтэц

- Нийгмийн даатгалын сангаас олгодог тэтгэвэр тэтгэмжүүд 7+ нэр төрөл байгаагаас нийт судалгаанд оролцогчдын 30%-г өндөр насны тэтгэвэр авагчид, 13%-г хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр авагчид, 5%-г тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагчид, 0.5%-г хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэвэр авагчид, 2.5%-г жирэмсний болон амаржсаны тэтгэмж авагчид, 0.4%-г оршуулгын тэтгэмж 0.3%-г ажилгүйдлийн тэтгэмж, 0.5%-г бусад тэтгэвэр тэтгэмж бүрдүүлсэн.


- Нийгмийн халамжийн сангаас 7+ нэр төрлийн тэтгэмж олгосон ба нийт судалгаанд оролцогчдын 6%-г өндөр настны, 17%-г тэжээгч нь нас барсан, 5%-г жирэмсэн болон 0-3 хүртэлх насны хүүхэдтэй эхчүүд, 6%-г хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх хүүхдийн мөнгөн тэтгэмж, 1%-г ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэнд, 3%-г эхийн алдар 1, 2 дугаар зэргийн одон, 9%-г бусад тэтгэмж тусламж тус тус бүрдүүлжээ.

- Өрхийн орлогод ЗГ-ын тэтгэвэр тэтгэмжийн хэмжээ орлогын бүлгүүдээр харилцан адилгүй тархаж байсан ба хамгийн бага орлоготой 20%-ийн өрхийн халамжийн орлого өрхийн нийт орлогын дунджаар 22%, хамгийн өндөр орлоготой бүлгийн 4%-ийг бүрдүүлсэн. Халамжийн голлох хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэмж (27-36%), хүүхдийн мөнгөн тэтгэмж (26-28%), тэжээгчээ алдсаны тэтгэмж (8-14%) тус тус бүрдүүлжээ.

4.2. Хөдөлмөрийн зах зээл, бодлого

МУ-ын хөдөлмөрийн зах зээл дэх эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин дэлхийн улс орнуудтай харьцуулахад өндөр (52.7%) байдаг ч, эрэгтэйчүүдийнх харьцангуй доогуур түвшинд (66.2%) байдаг. Үүнээс шалтгаалан нийт ажиллах хүчний оролцоо ч харьцангуй доогуур түвшинтэй (59.3%) байна (Зураг 4).

Зураг 4. 2016 оны байдлаар ажиллах хүчний оролцооны түвшин, ОУ-ын харьцуулалт



Эх сурвалж: Дэлхийн банк

МУ-д хөдөлмөр эрхлэлтэд төрөөс хэрэгжүүлж буй бодлогын хэрэгсэл тодорхой бус, хязгаарлагдмал байдаг. Тухайлбал хөдөлмөрийн татвар нь уян хатан бус тул төрөөс татвараар дамжуулан ажил эрхлэлтэд нөлөөлөх боломжгүй, ажилгүйдлийн тэтгэмжид 2018-2020 онд дунджаар ердөө 1860 гаруй ажилчид хамрагддаг, төрөөс зөвхөн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тодорхойлох, гадаад ажилчдын тоонд зохицуулалт хийх зэрэг хязгаарлагдмал хэрэгслээр хөдөлмөрийн зах зээлд оролцож ирсэн.


Цаашилбал сүүлийн жилүүдийн эдийн засгийн тогтворгүй байдал, инфляци зэрэг нь бодит цалингийн өсөлтийг бууруулах чиглэлд үйлчилж байна. Үүний улмаас иргэд гадаадад шилжин суурьших явдал нэмэгдэж, нийт ажиллах хүчний оролцооны түвшин, хөдөлмөр эрхлэлтэд сөргөөр

нөлөөлжээ. Харин хөдөөд уламжлалт мал аж ахуй эрхэлж байсан эрэгтэйчүүд хот, суурин газар шилжиж албан ажил эрхлэхтэй холбоотойгоор эрэгтэйчүүдийн ажил эрхлэлт бага зэрэг өсчээ. Эсрэгээр нь эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо, хөдөлмөр эрхлэлтийн түвшин тасралтгүй буурах төлөвтэй байна.


Цаашилбал эдийн засгийн хүндрэл, хөдөөд ажлын байрны хомсдол, хөдөөнөөс хотруу шилжих хөдөлгөөн нэмэгдсэнээр хотын ажилгүйдэл нэмэгдсэн зэргээс ажилгүйдлийн түвшин тогтворгүй, өндөр байна. МУ-ын хувьд эмэгтэйчүүдтэй харьцуулахад эрэгтэйчүүдийн ажилгүйдэл өндөр байжээ.

Зураг 5. МУ-ын хөдөлмөрийн зах зээл


2а. Ажиллах хүчний оролцооны түвшин




2б. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин



2в. Бодит цалин (ХҮИ-ээр засварласан)



2б. Ажилгүйдлийн түвшин



Эх сурвалж: Үндэсний Статистикийн хороо

Анхаарах: Ажиллах хүчний оролцооны түвшин нь хөдөлмөрийн насны хүн амын хэдэн хувийг ажиллах хүчин эзэлж байгааг харуулдаг үзүүлэлт юм. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин нь хөдөлмөрийн насны хүн амын хэдэн хувийг ажиллагчид эзэлж байгааг харуулдаг үзүүлэлт юм.

5. ЭМПИРИК ШИНЖИЛГЭЭ, ҮР ДҮН

5.1. Тоон мэдээлэл, загвар

Хувь хүмүүс амьдарлынхаа тодорхой үе шатанд ажиллах эсэхээ шийдвэрлэхдээ ажилласнаас олох харьцангуй үр ашгийг тооцдог бөгөөд энэ нь олон төрлийн хүчин зүйлсээс шалтгаалдаг. Тухайлбал тухайн хүний нас, хүйс, боловсролын түвшин, өмнөх ажлын байр, гэр бүлийн бүтэц зэрэг олон төрлийн нийгэм, эдийн засгийн хүчин зүйлс ажиллах шийдвэрт нөлөөлдөг. Тус судалгаанд хөдөлмөрийн зах зээл дэх халамжийн нөлөөг үнэлэхдээ хамаарах хувьсагчдад эмэгтэй, эрэгтэй, нийт иргэдийн тус бүрийн хувьд (i) ажиллах хүчний оролцооны түвшин, (ii) ажил эрхлэлтийн түвшин, (iii) ажилгүйдлийн түвшин, (iv) хувиараа аж ахуй эрхлэгчдийн хувь, (v) дундаж цалин зэрэг хувьсагчдыг авч үзнэ. Харин үл хамаарах хувьсагчдад (i) төсвөөс олгосон нийгмийн халамжийн зардал (ii) өрхийн орлого, (iii) эдийн засгийн мөчлөгийн (iv) бүтцийн, (v) бодлогын хувьсагчдыг авч үзнэ. Судалгаанд ашигласан тоон мэдээллийн дэлгэрэнгүйг Хүснэгт 5-д нэгтгэн харууллаа.

Хүснэгт 5. Шинжилгээнд ашигласан хувьсагчид

I	Хамаарах хувьсагчид				
	1. Ажиллах хүчний оролцооны түвшин	2. Ажил эрхлэлтийн түвшин	3. Ажилгүйдлийн түвшин	4. Хувиараа аж ахуй эрхлэгчдийн хувь	5. Дундаж цалин
A	Нийт	Нийт	Нийт	Нийт	Нийт
Б	Эрэгтэйчүүд	Эрэгтэйчүүд	Эрэгтэйчүүд	Эрэгтэйчүүд	Эрэгтэйчүүд
В	Эмэгтэйчүүд	Эмэгтэйчүүд	Эмэгтэйчүүд	Эмэгтэйчүүд	Эмэгтэйчүүд

II	Үл хамаарах хувьсагчид				
A	1. Халамжийг тодорхойлох хувьсагчид	2. Өрхийн орлогын хувьсагчид	3. Эдийн засгийн мөчлөгийн хувьсагчид	4. Бүтцийн хувьсагчид	5. Бодлогын хувьсагч
Б	Нийгмийн халамжийн сангийн зардал	Өрхийн нийт орлого	ДНБ-ий зөрүү	Шинээр төрсөн хүүхэд	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ
В			Экспортын үнийн индекс	Удирдах түвшний эмэгтэйчүүдийн хувь	
С			Бодит эдийн засгийн өсөлт		

Эх сурвалж: YCX, Монголбанк, Сангийн яам

Тоон мэдээллийн хувьд 2006 оны 1-р улирлаас 2020 оны 1-р улирал хүртэлх хугацааг хамрах боловч хөдөлмөрийн зах зээлийн зарим тоон мэдээллүүд бүрэн бус, дундаа тасралттай байгааг харгалзвал, олон төрлийн хувьсагч сонгон авахад хүндрэл учирсан. Цаашилбал эконометрик

аргазүйн хувьд хязгаарлагдмал, мөн олон хувилбартай үнэлгээг хялбар гүйцэтгэх боломжтой тул дараах олон хувьсагчтай энгийн регрессийн (OLS) аргыг ашиглалаа. Үнэлгээг (i) нийт иргэдийн, (ii) эрэгтэйчүүдийн, (iii) эмэгтэйчүүдийн хувьд тус тусд гүйцэтгэх ба дараах боломжит ялгаатай үл хамаарах хувьсагчдыг сонгон авч, эцсийн загварыг тодорхойлсон.

Нийт иргэдийн хувьд:

$$Var_{all} = \beta_0 + \beta_1 * SP + \beta_2 * Real\ HH\ income + \beta_3 * Real\ average\ wage + \beta_4 * GGDP + \beta_5 * GDP\ gap + \beta_6 * Export\ price\ index + \beta_7 * Min\ wage + e$$

Эрэгтэйчүүдийн хувьд:

$$Var_{all} = \beta_0 + \beta_1 * SP + \beta_2 * Real\ HH\ income + \beta_3 * Men\ average\ wage + \beta_4 * GGDP + \beta_5 * GDP\ gap + \beta_6 * Export\ price\ index + \beta_7 * Min\ wage + e$$

Эмэгтэйчүүдийн хувьд:

$$Var_{women} = \beta_0 + \beta_1 * SP + \beta_2 * Real\ HH\ income + \beta_3 * Women\ real\ average\ wage + \beta_4 * GGDP + \beta_5 * Export\ price\ index + \beta_6 * Min\ wage + \beta_7 * new\ baby\ growth + \beta_8 * share\ of\ women\ at\ the\ top\ position + e$$

Үүнд:

SP ~ Төсвөөс санхүүжилттэй халамжийн зардал, ХҮИ-ээр засварласан, логарифм авснаар;

Export price index ~ Экспортын үнийн индекс, логарифм авснаар;

Real HH income ~ Өрхийн нийт орлого, ХҮИ-ээр засварласан, логарифм авснаар;

Min wage ~ Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, логарифм авснаар;

Real average wage ~ Нийт дундаж бодит цалин, ХҮИ-ээр засварласан, логарифм авснаар;

New baby growth ~ Шинээр төрсөн хүүхдийн тооны өсөлт;

Men real average wage ~ Эрэгтэйчүүдийн дундаж бодит цалин, ХҮИ-ээр засварласан, логарифм авснаар;

Share of women at the top position ~ Удирдах түвшний эмэгтэйчүүдийн хувь;

Women real average wage ~ Эмэгтэйчүүдийн дундаж бодит цалин, ХҮИ-ээр засварласан, логарифм авснаар;

GGDP ~ Улирлын нөлөөг хассан, бодит ДНБ-ий өсөлт

GDP gap ~ ДНБ-ий зөрүү, МБ-ны МБГ-аас ирүүлсэн мэдээлэл;

Энгийн олон хувьсагчтай загварыг оновчтой тодорхойлохын тулд R статистикийн программын “*olsr*” командын багцнаас AIC шинжүүрийг ашиглаж, тогтоосон. Уг аргазүй нь хувьсагчдын олон боломжит хувилбартай үед боломжит бүх загваруудаас хамгийн оновчтой сонгон авахад туслах

бөгөөд үнэлгээг хялбар гүйцэтгэхэд тусладаг.

5.2. Шинжилгээний үр дүн

Олон хувьсагчтай загвар бүрийн хувьд үлдэгдлийн диагностик тестүүдийг шалгаж, товч үр дүнг Хүснэгт 6-д харууллаа. Үүнд:

ЗГ-аас санхүүжилттэй халамжийн сангийн зардал өсөхөд хөдөлмөрийн зах зээл дээр ажиллах хүчний оролцоо, хувиараа ажил эрхлэлт, бодит цалин буурах нөлөөтэй, харин ажилгүйдлийн түвшин өсөх нөлөөтэй, гэвч үнэлэгдсэн коэффициентууд статистикийн хувьд ач холбогдолгүй, мөн харьцангуй бага хэмжээтэй байна. Харин халамж 1 хувиар өсөхөд нийт хувиараа ажил эрхлэлт 0.0004 нэгж хувиар, эрэгтэйчүүдийнх 0.0005 нэгж хувиар тус тус өсөхөөр үнэлэгдсэн нь статистикийн хувьд ач холбогдолтой байсан.

Сонгон авсан үл хамаарах хувьсагчдаас хөдөлмөрийн зах зээлд өрхийн бодит орлого хамгийн өндөр нөлөөтэй байсан ба үнэлэгдсэн коэффициентүүд мөн статистикийн хувьд ач холбогдолтой байсан. Тухайлбал өрхийн бодит орлого 1 хувиар өсөхөд нийт ажиллах хүчний оролцоо 0.069 нэгж, үүнд эмэгтэйчүүдийнх 0.103 нэгж, нийт ажил эрхлэлт 0.069 нэгж, үүнд эмэгтэйчүүдийнх 0.122 нэгж хувиар, нийт хувиараа ажил эрхлэлт 0.0020 нэгж, үүнд эмэгтэйчүүдийнх 0.0021 нэгж хувиар тус тус өсөх хүлээлттэй байна. Харин бодит дундаж цалин 1 хувиар өсөхөд ажиллах хүчний оролцооны түвшин 0.046 нэгж, үүнд эмэгтэйчүүдийнх 0.107 нэгж, ажил эрхлэлт эрэгтэйчүүдийн хувьд 0.081, эмэгтэйчүүдийн хувьд 0.106 нэгж хувиар, нийт ажилгүйдлийн түвшин 0.06 нэгж хувиар, эрэгтэйчүүдийнх 0.059 нэгж хувиар тус тус буурах нөлөөтэй үнэлэгдсэн.

Эдийн засгийн мөчлөгийн хувьсагчдаас бодит эдийн засаг 1 хувиар өсөхөд бодит дундаж цалин 0.75, үүнд эрэгтэйчүүдийнх 0.73, эмэгтэйчүүдийнх 0.84 нэгж хувиар өссөн, мөн эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин 0.011 нэгж хувиар буурах нөлөөтэй байжээ. Харин ДНБ-ий зөрүү хувиараа ажил эрхлэлт, бодит дундаж цалин, ажилгүйдлийн түвшинд нөлөөлдөг, ч маш бага нөлөөтэй байв. Экспортын үнэ 1 нэгж хувиар өсөхөд ажил эрхлэлтийн түвшин 0.033, үүнд эрэгтэйчүүдийнх 0.044 нэгж хувиар тус тус өссөн, харин хувиараа аж ахуй эрхлэх хандлагад харьцангуй бага нөлөөтэй байна.

Бүтцийн хувьсагчдаас шинээр төрсөн хүүхдийн тоо, удирдах түвшний эмэгтэйчүүдийн хувь хэмжээ эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэд нөлөөгүй үнэлэгдсэн. Харин удирдах түвшний эмэгтэйчүүдийн хувь 1 нэгж хувиар нэмэгдэхэд эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо 0.29 нэгж хувиар өсөх нөлөөтэй үнэлэгджээ.

Бодлогын хувьсагчдаас хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нь ажил эрхлэлт болон ажилгүйдлийн түвшинд харьцангуй өндөр нөлөөтэй. Тухайлбал хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 1 хувиар өсөхөд нийт ажил

эрхлэлт 0.0413, үүнд эрэгтэйчүүдийн ажил эрхлэлт 0.043 нэгж хувиар тус тус буурах хүлээлттэй байна. Харин нийт ажилгүйдлийн түвшин 0.031 нэгж хувиар, үүнд эрэгтэйчүүдийнх 0.037, эмэгтэйчүүдийнх 0.062 нэгж хувиар тус тус өсөх нөлөөтэй үнэлэгдсэн.

6. СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ

Энэхүү судалгаанд сүүлийн жилүүдэд МУ-д төрөл, хэмжээний хувьд хурдацтай нэмэгдэж буй халамжийн хөтөлбөрүүдийн хөдөлмөрийн зах зээл дэх нөлөөг тодорхойлохыг зорилоо. ОУ-д энэ чиглэлээр хийгдсэн судалгаанууд дийлэнхдээ өрхийн түвшний тоон мэдээлэлд үндэслэдэг ба тухайн нэг халамжийн зорилтот бүлгүүд дэх зан төлөвийн болон орлогын нөлөөллийг шинжилсэн ажлууд түгээмэл байна. Харин макро түвшний тоон мэдээллийг ашигласан судалгаа хомс байдаг.

Төрөл бүрийн халамж хөдөлмөрийн зах зээлд олон төрлийн сувгуудаар дамжин нөлөөлдөг. Тухайлбал тус судалгаанд (1) орлого/амралтын орлуулалтын нөлөө, (2) эрүүл мэндээс үүдэлтэй бүтээмжийн нөлөө, (3) хувиараа аж ахуй эрхлэлтийн хөрөнгийн нөлөө, (4) хүмүүн капитал хуримтлалын нөлөө, (5) даатгалын нөлөө, (6) ажил хайхад хөрөнгө оруулах нөлөө, (7) ажиллах/ажиллахгүй байх нөхцөлийн нөхцөлт нөлөө, (8) нөхцөлт үйл ажиллагаанаас хамаарах нөхцөлт нөлөө, (9) хүмүүн капитал/айлгах нөлөө, (10) ерөнхий тэнцвэрийн нөлөөнүүдийг тодорхойлж, тайлбарласан. Эдгээр олон төрлийн сувгууд ажил эрхлэлтэд харилцан ялгаатай, эсрэг нөлөө үзүүлж буй учир нийт нөлөөг шууд тодорхойлоход төвөгтэй, олон талтай байна.

Хүснэгт 6. Олон хувьсагчтай энгийн регрессийн загварын үр товч үр дүн

Үл хамаарах хувьсагч	Ажиллах хүчний оролцоо		Ажил эрхлэлт		Хувиараа ажил эрхлэлт		Бодит дундаж цалин		Ажилгүйдлийн түвшин	
	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт	Эрэгтэй	Нийт	Эрэгтэй
Халамжаар хувьсагч										
<i>Тогтмол</i>										
1. Халамжийн хувьсагчид Халамжийн нийт зардал	-1.71 [-0.07]	8.70 [0.31]	-25.60 [-0.70]	-22.39 [-0.73]	29.34* [2.19]	-52.10 [-1.33]	-2.60*** [-5.06]	-2.72*** [-4.71]	0.17*** [43.84]	-5.20*** [-4.74]
	-0.67 [-1.52]	-0.22 [-0.39]		0.01 [0.01]	0.24 [0.29]		-0.04** [-2.80]	-0.05** [-3.30]		-0.01 [-0.93]
2. Өрхийн орлого Өрхийн нийт орлого	6.88* [2.54]	4.93 [1.64]	10.31** [3.00]	6.88* [2.04]		12.22** [3.32]	0.20*** [5.41]	0.21*** [5.06]		0.01 [0.361]
	-4.63* [-2.17]	-1.18 [-0.49]	-10.69*** [-4.54]	0.95 [0.24]	8.17* [2.15]	-10.55*** [-4.19]				
3. Макро ЭЗ-ийн үзүүлэлт (нийт, эр, эм) Эдийн засгийн өсөлт										
							0.75*** [7.71]	0.73*** [8.70]	0.84*** [22.65]	
ДНБ-ий зөрүү Экспортын үнийн индекс	-0.05 [-0.53]	0.07 [1.04]		0.04 [0.43]	0.00 [0.01]		0.00 [-1.50]	-0.00^ [-1.77]	-0.17** [-3.26]	-10.94* [-2.11]
	2.28 [1.56]			3.28* [2.02]	4.36* [2.07]			0.07* [1.73]	-0.20** [-3.41]	
4. Бүтцийн хувьсагчид Шинээр төрсөн хүүхэд										
Удирдах түвшний эмэгтэйчүүдийн хувь										
4. Бодлогын хувьсагчид Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ										
R2	0.32 4.9(0.0)	0.37 4.8(0.0)	0.55 8.6(0.0)	0.42 4.7(0.0)	0.39 5.2(0.0)	0.50 6.9(0.0)	0.72 25.9(0.0)	0.72 26.7(0.0)	0.16 2.0(0.12)	0.96 388(0.0)
F stat (P value)										
BP test (P value)	0.38	0.09	0.69	0.37	0.42	0.95	0.53	0.80	0.03	0.22
Устгасан тохиолдол	11	11	24	11	11	24	12	12	21	9
							9	9	9	9
							3.08^	3.72^	6.32**	
							[1.77]	[1.73]	[2.83]	
							0.35	0.28	0.27	
							5.97(0.00)	4.31(0.00)	2.96(0.03)	
							0.94	0.69	0.77	
							9	9	20	

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол, ***~ 0.001, **~ 0.01, * ~ 0.05, '^' 0.1 хувийн ач холбогдолын түвшинд тухайн регрессийн коэффициент статистикийн хувьд ач холбогдолтойг, харин тэмдэглэгээгүй тохиолдолд ач холбогдлогүйг илэрхийлнэ.

МУ-д хэрэгжүүлсэн халамжийн хөтөлбөрүүд зорилтод бүлэг иргэд, өрхүүдийн шаардлагыг хангаж, оновчтой тодорхойлогдож байгаа нь эргэлзээтэй байдаг. Нэгдүгээрт уул уурхайн бүтээгдэхүүнүүдийн үнийн өсөлт зэрэг эдийн засгийн бүтцийн эерэг өөрчлөлтүүдээс шалтгаалж 2005-2006 оноос хавтгайруулан олгосон олон төрлийн нийгмийн халамжудыг эдийн засгийн мөчлөг дагасан байдлаар хэрэгжүүлж ирсэн нь улсын төсөв, цаашилбал өрөнд сөргөөр нөлөөлсөн. Зарим жилүүдэд төсөвт суулгасан халамжийн зардал ДНБ-ын 4-5 хувь хүртэл нэмэгдсэн байна. Хоёрдугаарт хүүхдийн мөнгөн тусламж зэрэг зарим халамжийн хөтөлбөрийг хэт хавтгайруулсан нь тухайн хөтөлбөрийн зорилтот бүлгийн нэг өрхөд ногдох үр өгөөжийг бууруулах, төсвийн мөнгийг үр ашиггүй зарцуулах үндэс болж байна. Гуравдугаарт халамжийн зардлын бүтцээс харвал хамгийн бага орлоготой 20 хувийн өрхийн орлогын зөвхөн 22 хувийг халамжийн орлого бүрдүүлж байгаа ч тухайн өрхүүдийн ажил эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөтөлбөрүүд хомс байна.

Цаашилбал сүүлийн жилүүдэд манай улсын ажиллах хүчний оролцооны хэмжээ аажим буурсан нь дотоодын эдийн засгийн тогтворгүй байдал нэмэгдсэн, бодит цалингийн өсөлт эрс буурсан, хөдөлмөрийн шилжих хөдөлгөөн нэмэгдсэн, технологийн дэвшил зэргээс шалтгаалан зарим ажлын байрнаас хөдөлмөр шахагдсантай холбоотой. Манай улсын ажиллах хүчний оролцооны түвшин дэлхийн улс орнуудтай харьцуулахад харьцангуй бага түвшинд буюу 2016 оны байдлаар 59.2 хувьтай байжээ. Уг үзүүлэлт дэлхийн дунджаар 62.1, өр ихтэй улсуудын хувьд 71.6, хөгжил багатай улс орнуудын хувьд 68.3 хувь байжээ.

Тус судалгаагаар голч нийгмийн халамжийн хөдөлмөрийн зах зээлд хэрхэн нөлөөлж байгааг энгийн регрессийн загварууд ашиглан, тооцлоо. Үнэлгээний үр дүнд ажиллах хүчний оролцооны түвшин, ажил эрхлэлт, бодит дундаж цалин, ажилгүйдлийн түвшинд төсвөөс олгогдсон халамжийн зардал нөлөөгүй нь тогтоогдсон. Зөвхөн хувиараа аж ахуй эрхлэх хандлагыг маш багаар бууруулах нөлөөтэй байна. Харин бодит эдийн засгийн өсөлт, ДНБ-ий зөрүү, экспортын бүтээгдэхүүний үнэ зэрэг эдийн засгийн мөчлөгийн хүчин зүйлс хөдөлмөрийн зах зээлд өндөр нөлөөтэй нь тогтоогдлоо. Цаашилбал хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ ажил эрхлэлт, бодит дундаж цалин болон ажилгүйдлийн түвшинд өндөр нөлөөтэй байв. Эцэст нь шинээр төрсөн хүүхдийн тоо эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтэд нөлөөгүй үнэлэгдсэн.

Эдгээрээс дүгнэхэд МУ-д хэрэгжүүлж буй халамжийн хөтөлбөрүүдийн үндэслэлийг сайжруулах, нөлөөллийн шинжилгээг гүйцэтгэхэд нарийвчилсан микро түвшний тоон мэдээллийг бүрдүүлэх, эдийн засаг, ялангуяа хөдөлмөрийн зах зээл дэх эерэг нөлөөг нэмэгдүүлэхийн тулд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай. Энэ нь төсвийн ачааллыг бууруулахаас гадна иргэдийн хөдөлмөр эрхлэлт, оролцоог нэмэгдүүлж улмаар эдийн засгийн өсөлтөд эерэгээр нөлөөлөх талтай.

ХАВСРАЛТ

Хүснэгт 7. Нийгмийн халамжийн сангийн зарцуулалт 2015-2018 он

Үйлчилгээний төрөл	2015		2016		2017		2018	
	хүн	сая төг	хүн	сая төг	хүн	сая төг	хүн	сая төг
1. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	199 643	153 761	276 968	154 751	264 328	153 634	215 830	137 770
Халамжийн тэтгэвэр	59 300	86 408	65 110	86 701	61 613	85 105	59 670	88 818
Нөхцөлт мөнгөн тэтгэмж	140 343	67 353	211 858	68 051	202 715	68 529	156 160	48 952
Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн	94 947	38 651	145 675	36 324	143 193	34 096	95 404	12 156
Ахмад настныг асарч буй иргэний	21 615	13 436	32 737	15 558	30 366	17 116	31 329	18 615
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэний	21 023	13 242	30 438	14 219	26 518	15 335	26 835	16 188
Бүтэн өнчин хүүхэд үрчлэн өсгөсний	2 758	2 025	3 008	1 950	2 638	1 982	2 592	1 993
2. Нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлт	475 767	89 603	640 940	92 321	465 005	97 053	401 591	92 998
Ахмад настуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	163 289	22 245	312 935	23 579	141 582	23 994	104 469	24 279
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	51 419	9 465	40 871	9 143	40 048	8 947	11 610	8 206
Нийгмийн халамжийн үйлчилгээ	7 624	1 667	2 430	1 665	10 379	1 660	4 912	667
Нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж	248 675	51 330	282 046	53 379	268 751	57 870	275 304	54 816
Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	4 760	4 896	2 658	4 555	4 245	4 582	5 296	5 029
3. Хүүхдийн мөнгөн тэтгэмж	1,029,447	246,625	1,021,078	197,943	1,076,360	257,653	950 000	209 022

Хүснэгт 8. Ажил эрхлэлтийн түвшин

Үзүүлэлт	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
1 Нийт			62	63	64	62	62	62	61	61	61	61
2 Хүйсээр												
Эрэгтэй			67	69	69	68	69	68	67	67	70	68
Эмэгтэй			56	57	58	56	56	56	54	55	54	54
3 Насаар												
15-19	18	12	16	18	28	14	12	11	10	10	11	12
19-24	53	54	52	52	54	54	54	53	52	50	53	57
25-29	79	79	76	76	77	78	79	75	76	74	74	76
30-34	83	82	81	81	81	81	82	82	79	81	81	80
35-39	84	85	85	85	85	84	85	84	83	82	83	83
40-44	86	86	86	86	86	85	86	86	83	84	84	85
45-49	81	82	83	83	82	84	82	84	82	83	84	82
50-54	69	71	72	72	71	72	71	72	72	73	73	74
55-59	47	45	52	52	49	49	45	46	46	48	49	49
60-64	25	19	27	29	26	25	19	22	22	25	21	26
65-69	21	16	20	18	20	15	16	13	15	16	16	16
70+	12	7	7	10	12	7	7	6	7	8	8	7
4 Байрлал												
Баруун			73	72	76	72	74	73	72	73	72	64
Хангай			68	68	73	73	71	69	71	71	69	67
Төв			68	71	66	64	63	63	64	68	67	65
Зүүн			54	58	64	62	62	66	63	59	59	63
УБ			53	54	53	53	55	54	52	53	53	55

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Alzia, M. L. (2013). Welfare programs and labor supply in developing countries: experimental evidence from Latin America. *Springer*, 1255--1284.
- Asfaw, S., Davis, B., Dewbre, J., Handa, S., & Winters, P. (2014). Cash transfer programme, productive activities and labour supply: evidence from a randomised experiment in Kenya. *The Journal of Development Studies*, 1172--1196.
- Attanasio, O., Gomez, L. C., Rojas, A. G., & Vera-Hernandez, M. (2004). Child health in rural Colombia: determinants and policy interventions. *Economics and Human Biology*, 411-438.
- Baird, S., McKenzie, D., & Ozler, B. (2018). The effects of cash transfers on adult labor market outcomes. *IZA Journal of Development and Migration*, 1/22.
- Batchuluun, A., & Dalkhjab, B. (2014). Labor Force Participation and Earnings in Mongolia. *National University of Mongolia*.
- Dandarchuluun, K. a. (2019). The effect of universal child benefit on female labor supply: case of mongolia. *Asian Journal of Social Sciences & Humanities Vol, 2*.
- De Brauw, A., Gilligan, D. O., Hoddinott, J., & Roy, S. (огноо байхгүй). Bolsa Familia and household labor supply. *University of Chicago Press Chicago, IL*, 423--457.
- Foguel, M. N., & Barros, R. P. (2010). The effects of conditional cash transfer programmes on adult labour supply: an empirical analysis using a time-series-cross-section sample of Brazilian municipalities. *Estudos Econ\^o\micos (S\~a\o Paulo)*, 259--293.
- Galiani, S., & McEwan, P. J. (2013). The heterogeneous impact of conditional cash transfers. *Journal of Public Economics*, 85--96.
- Garganta, S., & Gasparini, L. (2015). The impact of a social program on labor informality: The case of AUH in Argentina. *Journal of Development Economics*, 99--110.
- Grigoli, F. a. (2018). Drivers of Labor Force Participation in Advanced Economies: Macro and Micro Evidence. *International Monetary Fund*.
- Haushofer, J., & Shapiro, J. (2013). Household response to income changes: Evidence from an unconditional cash transfer program in Kenya. *Massachusetts Institute of Technology*, 1--57.
- Pavao, N. (2016). Conditional cash transfer programs and electoral accountability: Evidence from Latin America. *Latin American Politics and Society*, 74-99.
- Ribas, R. P., & Soares, F. V. (2011). Is the effect of conditional transfers on labor supply negligible everywhere. *Unpublished manuscript, Tinker Fellowship, Center for Latin American and Caribbean Studies, University of Illinois at Urbana-Champaign*.